



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/441

Мандалговь

Малын түүвэр судалгаа
явуулах тухай

Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд 2020 оны хагас жилийн малын түүвэр судалгааг явуулах аймгийн комиссыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хагас жилийн малын түүвэр судалгааг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 5 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд Үндэсний Статистикийн хорооноос өгсөн заавар, чиглэлийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Статистикийн хэлтсийн дарга (Б.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

Гурав. Мал тооллогын түүвэр судалгаанд сумдад ажиллах комиссыг шинэчлэн томилж, заавар, чиглэлийн дагуу, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010399

Аймгийн засаг даргын 2020 оны 05 дугаар
сарын 27-ны өдрийн 44 дугаар
захирамжийн хавсралт



Аймгийн Малын түүвэр судалгааны
комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

О.Бат-Эрдэнэ (Аймгийн Засаг дарга)

Гишүүд:

А.Ганбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Мөнхжаргал (Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Энхтуяа (Статистикийн хэлтсийн дарга)

Т.Бямбасүрэн (Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

Г.Сайхантуяа (Статистикийн хэлтсийн зохион байгуулагч)